

**ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /9-р сарын 17-наас 10-р сарын 15-ны байдлаар, төгрөгөөр/**

№	Барааны нэр, төрөл	IX/17	IX/24	X/01	X/08	X/15
1	Гурил, I зэрэг, кг	1000	1000	1000	1000	1000
2	Хонины мах, кг/ ястай/	6500	6500	6000	5500	5500
3	Үхрийн мах, кг /ястай/	8500	8500	7500	7500	7500
4	Ямааны мах /ястай /	5500	5500	5000	5000	5000
5	Элсэн чихэр, кг	1600	1600	1600	1600	1600
6	Цагаан будаа, кг	2150	2200	2200	2200	2200
7	Шингэн сүү, л	900	1000	1000	1100	1200
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
9	- Бор ноолуур	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
10	Бензин, А-80, 1 литр	1570	1570	1570	1570	1570
11	Бензин, А-92, 1 литр	1690	1690	1690	1690	1690
12	Дизелийн түлш, 1 литр	1790	1790	1790	1790	1790

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2014 оны 9-р сарын 17-ноос 2014 оны 10-р сарын 15-ны хооронд “Алтан тариа” ХК 1-р гурил, элсэн чихэр, шатахууны ханш тогтвортой байсан бол хонь, үхэр, ямааны ястай махны үнэ буурч, шингэн сүү, цагаан будааны үнэ өсөв. Энэ хугацаанд ноолуурын арилжаа хийгээгүй байна.

**Махны үнэ.** Махны нийлүүлэлт ихэсч байгаатай холбоотойгоор сүүлийн 2 сар махны үнэ буурлаа. 9-р сарын 24-ны өдөр хүртэл хонины ястай мах 1 кг нь 6500 төгрөг байсан бол 10-р сарын нэгэн, 10-р сарын 8-ны өдрүүдийн мэдээгээр тус тус 500 төгрөгөөр буурч 5500 төгрөгийн ханштай болов. 8500 төгрөгийн ханштай үхрийн ястай мах 10-р сарын 1-нээс 11,8 хувиар, ямааны ястай мах мөн 10-р сарын 1-ээс 9,1 хувиар буурав.

**Гурил, элсэн чихэр, цагаан будаа.** Гурил, элсэн чихрийн үнэ сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой байлаа. Цагаан будааны үнэ 9-р сарын 24-нөөс өмнөх долоо хоногоос 50 төгрөгөөс өсөв.

**Шингэн сүү.** Шингэн сүүний үнэ 7 хоног тутам өсч байгаа ба 9-р сарын 17-нд 900 төгрөгийн ханштай байсан бол 10-р сарын 15-нд 33,3 хувиар өсч 1200 төгрөг болов.



